Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

# ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙХАН-ОВОО СУМЫН БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☑ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Төрийн албаны тухай хууль |
| Дагаж мөрдөх огноо: | 2021 |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | 2021.04.20 |

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газар | Баг |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
| Багийн Засаг дарга | УТ |
| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдрийн 8 цаг | Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газарын байр |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:** Төр засгийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын болон дээд шатны Хурал, Засаг дарга, Иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх, хүн амын эрүүл мэнд, боловсрол, амжиргааны түвшинг судлан статистикийн мэдээлэл гаргах, хууль тогтоомж, шийдвэрээр хүлээсэн үүргээ биелүүлэх

**Албан тушаалын зорилт:**

1. Төр засгийн бодлого, хууль тогтоомжид заагдсан бүрэн эрхийг хэрэгжүүлэх
2. Хүн амын эрүүл мэнд, боловсрол, амжиргааны түвшин, шилжилт хөдөлгөөний талаарх үнэн зөв мэдээлэл, бусад мэдээ, тоо баримтыг цуглуулах, судалгаа, мэдээ тайланд үндэслэн дэмжлэг үйлчилгээ үзүүлэх
3. Засгийн газрын болон дээд шатны Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чигүүрэг | Гүйцэтгэ-лийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - **Т**, Хариуцан гүйцэтгэх - **Г**Хянах – **Х** Шийдвэрлэх - **Ш** |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Төр, засгийн бодлого шийдвэр,хууль тогтоомжид заагдсан багийн Засаг дарга нарт холбогдолтой зүйл заалтуудын санг бий болгон мөрдөн хэрэгжүүлэх | Иргэд оршин суугчид төр засгийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулсан байх | Г |
| | 2. Багийн өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион байгуулах | Иргэдийн угийн бичиг хөтлөлт нэмэгдсэн байх | Т |
| | 3. Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах | Байгаль орчны бохирдол болон орчны өнгө үзэмж сайжирсан байх | Х |
| | 4. Түүх соёлын дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих | Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалт,шинээр илрүүлэх бүрдүүлэлт сайжрах | Х |
| | 5. Багийн Засаг дарга иргэдийг судлаж бүртгэх, хууль тогтоомжид заасан тэтгэвэр тэтгэмж, дэмжлэг, тусламжид хамруулахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх | Хуульд заасан тэтгэвэр тэтгэмжид хамрагдагсдын тоо нэмэгдэх | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Хүн амын эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгаа хийж, төсөл хөтөлбөрт хамруулах талаар санаачлага гарган ажиллах | Багийн иргэдийн амжиргааны түвшин, ажилгүйдлийн тоо буурсан байх | Г |
| | 2. ХАОМС, Малын тоо толгойн программуудын баяжуулалт, хөтлөлтийг тогтмол хийх,иргэдийн шилжилт хөдөлгөөн бусад мэдээллийг хугцаанд нь бүртгэх | Мэдээллийн сангийн программыг алдаагүй хөтөлсөн байх | Г |
| | 3. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг татан оролцуулж иргэдийн эрүүл мэндийг дэмжих | Иргэд эрт илрүүлэг үзлэгт хамрагдсанаар өвчлөл буурсан байх | Т |

| | | | |
|---|---|---|---|
| | 4. Иргэдийн боловсрол эзэмшсэн байдалд судалгаа хийж шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, суурь боловсрол эзэмшээгүй иргэнийг нөхөн эзэмшүүлэх | Иргэдийн боловсрол эзэмшилтийн судалгаанд тулгуурлан сумын хүний нөөцийн хангамжинд иргэдийг хамруулж сургууль завсардалтгүй болох | Г |
| | 5. Тайлан мэдээ, судалгаа статистик тоо баримтыг үндэслэн үнэн зөв гаргаж холбогдох газарт хугацаа алдалгүй хүргэж ажилла | Тайлан мэдээ,судалгаа үнэн зөв хугацаандаа хүрсэн байх | Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд<br><br>гэх мэт | 1.Дээд шатны Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлан хэрэгжүүлэх,тайлагнах | Бодлого шийдвэрийг иргэдэд түргэн шуурхай таниулан хэрэгжүүлж тайлагнасан байх | Г |
| | 2. БИНХ-ыг улирал тутам зохион байгуулж иргэддээ хүрч ажиллан иргэдийн санал бодлыг сонсох, түүнийг ажил хэрэг болгох | БИНХурлыг жилд 4-өөс доошгүй удаа хийсэн байх | Г |
| | 3. Удирдах албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хөдөө өрхүүдээр тойрох цаг үеийн байдалтай танилцах мэдээ мэдээлэл хүргэх ажлыг тухай бүрт чанартай зохион байгуулах | Удирдамжийн дагуу хөдөөгүйр ажилласан байх | Г |
| | 4. Хортон мэрэгчтэй тэмцэх, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах ажлуудыг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэж ажиллах | Малчдад тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж ажилласан байх | Г |

## III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | |
|---|---|
| **Боловсрол** | Бүрэн дунд, Тусгай дунд түүнээс дээш боловсролтой байх |
| **Мэргэжил** | Ямар ч мэргэжлийн байж болно |
| **Мэргэшил** | Төрийн удирдлагаар мэргэшсэн байх |
| **Туршлага** | Төрийн албаны дадлага туршлагатай байх |
| **Ур чадвар** | Удирдан зохион байгуулах, багаар ажиллах, судалгаа тайлан гаргах, компьютрийн оффисс программуудыг бүрэн ашигладаг байх |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: | |
|---|---|
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br>1. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга<br>2. Засаг дарга<br>3. Засаг даргын орлогч<br>4. Засаг даргын Тамгын газрын дарга<br>5. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга<br>6.Багийн Иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгчид<br>7. Багийн Иргэдийн Нийтийн хурлын дарга<br>Нийт: 7 | Бусад харилцах субъект<br><br>1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал<br>2. Аймгийн Засаг дарга түүний орлогч, Тамгын дарга<br>3. Нутгийн Захиргааны бусад байгууллага<br>4.Багийн иргэд<br>5.Багийн эмч |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** |
|---|---|
| Албан тушаал: Засаг даргын орлогч<br>.................................<br>Б.Арсланбаатар (Гарын үсэг)<br>(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2021 оны 04 дугаар сарын 20 -ны өдөр | Байгууллагын нэр: Сумын Засаг даргын захирамж<br><br>Шийдвэрийн огноо: 2021.04.20<br><br>Дугаар: А/27<br><br>(тамга/тэмдэг)<br>.................................<br>С.Амарсанаа<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2021 оны 04 дугаар сарын 20-ны өдөр |